


АГУУЛГА

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	2
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	2
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:	4
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	6
2.1. Нэгдсэн төсвийн орлого	7
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага	9
2.3. Төсвийн тэнцэл	10
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА	11
3.1. Гадаад худалдааны эргэлт:	11
3.2. Экспорт	12
3.3. Импорт	14
ДӨРӨВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	15
4.1. Мөнгөний нийлүүлэлт	15
4.2. Гадаад валютын албан нөөц	18
4.3. Төлбөрийн тэнцэл	19
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	20
5.1. Хүн ам, ажил эрхлэлт	20
5.2. Ажилгүйдэл	20
ДҮГНЭЛТ	21

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


Эцсийн ашиглалтын аргаар: 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр оны үнээр Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 7.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 их наяд төгрөг буюу 6.1 хувиар буурсан байна.



Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн¹ нь 2016 оны мөн үед 4.7 их наяд, 2017 оны мөн үед 5.6 их наяд, 2018 оны мөн үед 6.6 их наяд, 2019 оны мөн үед 7.7 их наяд төгрөгт хүрч тасралтгүй өсөлттэй байсан бол 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 7.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 их наяд төгрөгөөр буюу 6.1 хувиар буурсан үзүүлэлттэй гарчээ.

Нэрлэсэн ДНБ-ий дүн буурахад эцсийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 0.6 их наяд төгрөгөөр буюу 11.0 хувиар өссөн ч, хөрөнгийн хуримтлал 0.2 их наяд төгрөг буюу 6.1 хувиар, цэвэр экспорт 0.9 их наяд төгрөгөөр буюу 2.6 дахин буурсан нь нөлөөлсөн байна.

Эцсийн ашиглалтын аргаар: 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 2010 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 3.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.4 их наяд төгрөгөөр буюу 10.5 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна.




Зэрэгцүүлэх үнээр тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн² нь 2016 оны мөн үед 3.1 их наяд, 2017 оны мөн үед 3.2 их наяд, 2018 оны мөн үед 3.4 их наяд, 2019 оны мөн үед 3.7 их наяд төгрөгт хүрч байсан бол 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 3.3 их наяд төгрөг болж, 10.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

¹ - эцсийн ашиглалтын аргаар оны үнээр тооцоход

² - эцсийн ашиглалтын аргаар 2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцоолоход

2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий үзүүлэлт буурахад эцсийн хэрэглээ 0.2 их наяд төгрөг буюу 7.3 хувиар өссөн боловч хөрөнгийн нийт хуримтлал 32.5 тэрбум төгрөг буюу 2.4 хувиар, цэвэр экспорт 0.6 их наяд төгрөгөөр буюу 61.4 хувиар буурсан нь тус тус нөлөөлжээ.

ДНБ-ийг улирлаар харуулбал жил бүрийн нэгдүгээр улиралд ДНБ-ий хэмжээ тухайн жилийн хамгийн бага утгыг үзүүлдэг бол хоёрдугаар улирлаас хойш өсдөг зүй тогтол ажиглагдаж байна. 2016-2020 оны нэгдүгээр улирлын үзүүлэлтүүдийг 5 жилийн дунджаар авч үзвэл эцсийн хэрэглээ нь ДНБ-ий 75.7 хувийг, хөрөнгийн нийт хуримтлал нь 26.0 хувийг тус тус эзэлсэн бол цэвэр экспорт сөрөг 1.7 хувиар нөлөөлсөн байна.



2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр ДНБ-ий 88.2 хувь нь эцсийн хэрэглээнд, 33.0 хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, -21.2 хувь нь цэвэр экспортод ногдож байна. Хөрөнгийн нийт хуримтлалын ДНБ-нд эзлэх хувийн жин өсөх хандлагатай байгаа нь материаллаг эргэлийн хөрөнгө буурч байгаа ч үндсэн хөрөнгийн нийт хуримтлал өсч байгаатай холбоотой байна. Харин цэвэр экспорт өмнөх оны мөн үеэс буурахад бараа, үйлчилгээний экспорт болон импорт түүн дотроо чулуун нүүрс, зэсийн баяжмал, алтны экспортоос гадна аяллын болон бизнесийн бусад үйлчилгээний экспорт, импорт буурсан нь нөлөөлжээ.

Үйлдвэрлэлийн аргаар: Нэрлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 7.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 их наяд төгрөгөөр буурсан байна.

ДНБ өмнөх онтой харьцуулахад бага байгаа нь үйлчилгээ 68.6 тэрбум, хөдөө аж ахуй 47.2 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн ч, аж үйлдвэр 576.9 тэрбум, бүтээгдэхүүний цэвэр татвар 38.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр


Хүснэгт 1.

/тэрбум төгрөг/

Бүрэлдэхүүн	2016QI	2017QI	2018QI	2019QI	2020QI	Зөрүү
ДНБ	4,738.1	5,836.2	6,822.8	7,943.3	7,444.0	-499.3
Хөдөө аж ахуй ойн аж ахуй загас барилт ан агнуур	181.1	185.6	222.2	257.8	305.0	47.2
Уул уурхай, олборлолт	933.0	1,615.9	1,947.0	2,384.5	1,692.1	-692.4
Боловсруулах үйлдвэрлэл	413.9	540.9	658.0	712.4	784.9	72.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	159.9	159.4	183.7	198.8	231.7	32.9
Барилга	67.5	47.7	61.8	73.1	83.2	10.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	373.7	459.1	514.4	620.1	586.2	-33.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	289.2	333.9	373.5	419.8	328.2	-91.6
Мэдээлэл, холбоо	96.4	99.5	111.9	132.6	142.4	9.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1,772.9	1,850.2	1,984.7	2,291.5	2,475.8	184.3
Бүтээгдэхүүний цэвэр татвар	450.5	544.0	765.5	852.7	814.5	-38.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий 37.5 хувийг аж үйлдвэр, 47.5 хувийг үйлчилгээ, 4.1 хувийг хөдөө аж ахуй, үлдсэн 10.9 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлсэн байна.



2020 оны эхний улирлын байдлаар үйлдвэрлэлийн аргаар ДНБ-ийг оны үнээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбар 17.1 хувиар, бүтээгдэхүүний цэвэр татварын хэмжээ 4.5 хувиар буурсан бол хөдөө аж ахуйн салбар 18.3 хувиар, үйлчилгээний салбарын үйлдвэрлэл 2.0 хувиар тус тус өссөн байна.


2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 2010 оны зэрэгцүүлсэн үнээрх ДНБ-ий хэмжээ 3.1

их наяд төгрөгт хүрч, бодит ДНБ-ий 50.3 хувийг үйлчилгээ, 32.2 хувийг аж үйлдвэр, 4.9 хувийг хөдөө аж ахуй, 12.7 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлж байна.

1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:

2019 оны жилийн эцэст ДНБ-ий бодит өсөлт 5.1 хувьд хүрч, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ урьдчилсан дүнгээр 11,566.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 12.7 хувь буюу 1,306.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Харин 2020 оны нэгдүгээр улирлын байдлаарх Монгол Улсын эдийн засаг 10.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 5. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ба эдийн засгийн өсөлт



2011 онд ДНБ-ий бодит өсөлт 17.3 хувь байх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,917.1 мянган төгрөг байжээ. ДНБ-ий бодит өсөлт 2011-2016 онуудад тасралтгүй буурч, 2016 оны эцэст 1.2 хувьд буюу хамгийн доод цэгтээ хүрсэн байна. Харин нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ өсөх хандлагаа хадгалсан хэвээр байсан ба 2019 оны жилийн эцсээр ДНБ-ий өсөлт 5.1 хувьд хүрэх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 11,566.5 мянган төгрөгт (4,294.1 ам.доллар) буюу хамгийн өндөр утгандаа хүрчээ.

График 6. Эдийн засгийн өсөлт, улирлаар



Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн 2016-2020 оны нэгдүгээр улирлын төлвийг авч үзвэл тус хугацаанд жил дараалан өссөн дүнтэй байсан бол 2020 оны нэгдүгээр улирлын байдлаар 10.7 хувьд хүрч буурчээ. Үүнд салбаруудын оролцооны нөлөөллийг авч үзвэл уул уурхай, олборлолт, бүтээгдэхүүний цэвэр татвар, үйлчилгээний салбар тус тус тодорхой хувиар буурсан нь голлон нөлөөлж нийт эдийн засаг агшсан байна. ДНБ-ий 10.7 хувийн бууралтын -7.6 пункт нь уул уурхай, олборлолтын салбарт ногдож байгаа нь гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспорт өмнөх оны мөн үеэс буурсантай холбоотой байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2,073.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2,349.8 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 276.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 111.1 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 5.1 хувиар дутуу биелсэн бол төсвийн нийт зарлага 1,051.7 тэрбум төгрөг буюу 30.9 хувиар төлөвлөснөөс дутуу зарцуулагджээ.

Монгол Улсын нэгдсэн төсөв

Хүснэгт 2.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт (+/-)	
	1	2	(2-1)	(2-1)/1
	2020 оны нэгдүгээр улирал		Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	2,184.9	2,073.8	-111.1	5.1
Нийт зарлагын дүн	3,401.5	2,349.8	-1,051.7	-30.9
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1,216.5	-276.0	940.5	-77.3
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-3.0	-0.7		

Эх сурвалж: Сангийн яам

2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2,073.8 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 89.6 тэрбум төгрөг буюу 4.1 хувиар буурсан бол нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2,349.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 380.7 тэрбум төгрөг буюу 19.3 хувиар өссөн байна.

Нэгдсэн төсвийн өөрчлөлт, 2016-2020 оны нэгдүгээр улирлын байдлаар

Хүснэгт 3.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн эхний улирлын гүйцэтгэлээр					Өөрчлөлт(+/-)	
	2016	2017	2018	2019	2020	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	1,095.2	1,504.2	1,810.9	2,163.4	2,073.8	-89.6	-4.1
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,710.9	1,759.2	1,836.6	1,969.1	2,349.8	380.7	19.3
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-615.7	-255.1	-25.8	194.3	-276.0	-470.3	-242.0
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-2.6	-0.9	-0.1	0.5	-0.7		

Эх сурвалж: Сангийн яам

2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 276.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч энэ нь өмнөх оны мөн үеэс 470.3 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 0.7 хувь болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ДНБ-д эзлэх алдагдлын хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 276.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.7 хувьд хүрсэн нь төлөвлөсөн дүнгээс 940.5 тэрбум төгрөгөөр буурч сайжирсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөсөнд хүрч биелээгүй ч нийт зарлага хэмнэгдэж зарцуулагдсан нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал төлөвлөснөөс буурахад нөлөөлжээ.

2.1. Нэгдсэн төсвийн орлого

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2,073.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 4.1 хувь буюу 89.6 тэрбум төгрөгөөр буурч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 5.1 хувь буюу 111.1 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 92.2 хувийг татварын орлого, 7.8 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 5.4 хувь буюу 76.5 тэрбум, Орон нутгийн төсөв 7.8 хувь буюу 66.8 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн төсөв 5.6 хувь буюу 35.2 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 16.6 хувь буюу 21.1 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу биелсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 10.6 хувь буюу 159.6 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 6.9 хувь буюу 7.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан бол орон нутгийн төсвийн орлого 19.2 хувь буюу 126.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн орлого 7.9 хувь буюу 43.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

Хүснэгт 4.

/тэрбум төгрөг/


Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.	Төлөв.	Гүйцэт.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,593.6	1,495.7	854.0	787.2	630.7	595.5	126.7	105.7
ИРЭЭДҮЙН ӨВ САН	139.9	144.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	32.2	6.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,421.4	1,344.9	854.0	787.2	630.7	595.5	126.7	105.7
Татварын орлого	1,134.9	1,158.9	325.2	294.2	475.7	440.6	126.7	105.7
Орлогын албан татвар	319.6	331.7	223.2	214.9	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	475.7	440.6	126.7	105.7
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	47.2	32.3	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	342.6	392.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	199.4	179.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	3.7	3.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	161.3	148.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	108.3	102.8	54.8	46.9	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	286.5	186.0	528.8	493.1	154.9	154.9	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	143.1	123.1	53.6	33.8	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.2	0.2	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	82.7	57.7	2.2	1.9	154.9	154.9	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	60.7	5.2	472.8	457.2	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Татварын орлого 1,912.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 2.8 хувь буюу 54.3 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Татварын орлогын 28.6 хувийг орлогын албан татвар, 24.0 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.7 хувийг хөрөнгийн албан татвар, 20.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.4 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 7.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 7.8 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 3. Татварын орлого /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд зарим татварын орлогууд өссөн үзүүлэлттэй байна. Үүнд: орлогын албан татвар 0.7 хувь /3.9 тэрбум төгрөг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 14.6 хувь /50.1 тэрбум төгрөг/-иар өсчээ. Харин нийгмийн даатгалын орлого 9.3 хувь /47.3 тэрбум төгрөг/, хөрөнгийн албан татвар 31.6 хувь /14.9 тэрбум төгрөг/, онцгой албан татвар 10.0 хувь /19.9 тэрбум төгрөг/, тусгай зориулалтын орлого 6.0 хувь /0.2 тэрбум төгрөг/, гадаад үйл ажиллагааны орлого 7.8 хувь /12.6 тэрбум төгрөг/, бусад татвар, төлбөр хураамж 8.2 хувь /13.4 тэрбум төгрөг/-иар тус тус дутуу биелсэн байна.

Дутуу төвлөрсөн татварын орлогын өсөлтийн 43.7 хувийг нийгмийн даатгалын орлого, 13.8 хувийг хөрөнгийн албан татвар, 18.4 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 11.7 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 12.3 хувийг бусад татвар, төлбөр хураамжийн орлого тус тус эзэлж байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр татварын орлого 58.9 тэрбум төгрөг буюу 3.0 хувиар буурахад орлогын албан татвар 9.1 тэрбум (1.7%), нийгмийн даатгалын орлого 20.5 тэрбум (4.7%), хөрөнгийн албан татвар 4.5 тэрбум (16.3%), нэмэгдсэн өртгийн албан татвар 11.2 тэрбум (2.9%) төгрөгөөр тус тус нэмэгдсэн ч онцгой албан татвар 33.9 тэрбум (15.9%), тусгай зориулалтын орлого 0.7 тэрбум (16.1%), гадаад үйл ажиллагааны орлого 5.7 тэрбум (3.7%), бусад татвар, төлбөр, хураамж 63.9 тэрбум (29.9%) төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Татварын бус орлого 161.2 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 16.0 хувь буюу 30.7 тэрбум төгрөгөөр буурсан бол төлөвлөснөөс 56.8 тэрбум төгрөг буюу 26.1 хувиар дутуу төвлөрсөн байна.

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд гадаад хандив тусламжийн орлого 17.0 тэрбум, газрын тосны орлого 30.9 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 4.0 тэрбум, торгуулийн орлого 1.3 тэрбум, түрээсийн орлого 0.6 тэрбум, бусад орлого 9.8 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ. Харин хүүгийн орлого 6.2 тэрбум, хувьцааны ноогдол ашиг 0.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс илүү төвлөрчээ.

Татварын бус орлогын 97.3 хувийг нийтлэг татварын бус орлого, 2.6 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийт татварын бус орлогод эзлэх нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 33.6 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 23.7 хувийг навигацгийн орлого, 13.6 хувийг газрын тосны орлого, 10.0 хувийг хүүгийн орлого, 9.9 хувийг торгуулийн орлого, 8.5 хувийг бусад орлого, 0.3 хувийг хувьцааны ноогдол ашиг болон түрээсийн орлого тус тус эзэлж байна.

График 4. Татварын бус орлогын бүтэц /хувиар/



Эх сурвалж: Сангийн яам

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 3,401.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 69.1 хувийг ашиглаж 1,051.7 тэрбум төгрөг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 380.7 тэрбум төгрөг буюу 19.3 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 677.0 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 380.1 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 41.3 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 41.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 278.9 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсвийн зарлага 94.9 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 83.6 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 15.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл

Хүснэгт 5.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны мөн үе	Төлөв.	Гүйц.	Төлөвлөгөө биелэлт, %	Өөрчлөлт		
	2019Q1	2020Q1			Төлөв/Гүйцэт	Дүн	Хувь
	1	2	3	(3:2)	(3-1)	(3-1)/1	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,969.1	3,401.5	2,349.8	69.1%	380.7	19.3	
НИЙТ ЗАРЛАГА	1,968.5	3,418.2	2,373.5	69.4%	405.0	20.6	
УРСГАЛ ЗАРДАЛ	1,800.5	2,657.8	2,132.6	80.2%	332.1	18.4	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	826.5	1,288.3	964.5	74.9%	138.0	16.7	
ХҮҮ	171.1	192.9	185.3	96.1%	14.2	8.3	
ТАТААС	52.1	122.4	88.5	72.3%	36.4	69.8	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	750.8	1,054.2	894.3	84.8%	143.4	19.1	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	168.0	760.4	240.9	31.7%	73.0	43.4	
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.6	-16.7	-23.7	142.1%	-24.3	-4,396.1	

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 19.3 хувь буюу 380.7 тэрбум төгрөгөөр өсөхөд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 24.3 тэрбум төгрөгөөр буурсан ч урсгал зардал 332.1 тэрбум, хөрөнгийн зардал 73.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14.2 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар өссөн хэдий ч тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 7.6 тэрбум төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 90.8 хувь буюу 2,132.6 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 45.2 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 41.9 хувийг урсгал шилжүүлэг, 8.7 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.1 хувийг татаас эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 332.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, үйлчилгээний зардал 138.0 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 14.2 тэрбум, татаас 36.4 тэрбум, урсгал шилжүүлэг 143.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

2.3. Төсвийн тэнцэл

2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 276.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.7 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан байна.

Төсвийн тэнцэл

Хүснэгт 6.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн эхний улирлын байдлаар					Өөрчлөлт(+/-)	
						2020.03/2019.03	
	2016	2017	2018	2019	2020	Дүн	Хувь
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-615.7	-255.1	-25.8	194.3	-276.0	-470.3	-242.0
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-2.6	-0.9	-0.1	0.5	-0.7	-	-

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 495.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч орон нутгийн төсөв 183.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсөв 18.4 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 17.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 4.1 хувиар буурч, харин нийт зарлага 19.3 хувиар нэмэгдсэн байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 470.3 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөсөн хэмжээнээс 940.5 тэрбум төгрөгөөр буурч тэнцэл сайжирчээ.

2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 200.2 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 40.8 тэрбум төгрөг төлж, 80.1 тэрбум төгрөгийн гадаад төслийн болон 274.1 тэрбум төгрөгийн гадаад хөтөлбөрийн зээл тус тус шинээр авч, 61.3 сая төгрөгийн өмч хувьчлалын орлого төвлөрүүлжээ. Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд шинээр гаргаагүй байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

3.1. Гадаад худалдааны эргэлт:

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 28.1 хувь буюу 860.0 сая ам.доллараар буурч 2,197.4 сая ам.долларт хүрсэн байна.

Монгол Улс дэлхийн 124 улстай гадаад худалдаа хийснээс экспорт 735.9 сая ам.доллар буюу 41.5 хувиар, импорт 124.1 сая ам.доллар буюу 9.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Гадаад худалдааны тэнцэл сүүлийн гурван жил дараалан ашигтай гарсан ч коронавирусын нөхцөл байдалтай холбоотойгоор энэ оны нэгдүгээр улиралд алдагдалтай гарлаа.

Гадаад худалдааны үзүүлэлт

Хүснэгт 7.

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирал				Өөрчлөлт	
	2017	2018	2019	2020	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	2,076.1	2,612.9	3,057.4	2,197.4	-860.0	-28.1
-Экспорт	1,299.9	1,482.4	1,771.7	1,035.8	-735.9	-41.5
-Импорт	776.2	1,130.5	1,285.7	1,161.6	-124.1	-9.7
Тэнцэл	523.7	351.9	485.9	-125.8	-611.7	-125.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

Гадаад худалдааны тэнцэл: 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар гадаад худалдааны тэнцэл **125.8 сая** ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс **611.7 сая** ам.доллар буюу **125.9** хувиар буурахад экспортын **735.9** сая ам доллар болон импортын **124.1** сая ам.долларын бууралт нөлөөлсөн байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2020 оны 03 дугаар сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 558.0 сая ам.доллараар буурч 29 сая ам долларын алдагдалтай гарсан байна.

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 56.5% буюу 1,241.2 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 18.2% буюу 400.6 сая ам. долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 6.0%-иар өссөн бол БНХАУ-тай хийсэн худалдаа 34.4%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

Хүснэгт 8.

/сая ам.доллар/

Улс	Төрөл	1 дүгээр улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
		Эзлэх хувь	2018	2019	2020	2020.03/2019.03	
						Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	56.5	1661.0	1893.0	1241.2	-651.8	-34.4
	Экспорт	87.3	1301.7	1520.4	904.7	-615.7	-40.5
	Импорт	29.0	359.3	372.6	336.5	-36.1	-9.7
	Тэнцэл		942.4	1147.8	568.2	-579.6	-50.5
ОХУ	Нийт эргэлт	18.2	378.6	377.9	400.6	22.7	6.0
	Экспорт	1.1	17.3	14.9	11.0	-3.9	-26.2
	Импорт	33.5	361.3	363.0	389.6	26.6	7.3
	Тэнцэл		-344.0	-348.1	-378.6	-30.5	8.8
Бусад	Нийт эргэлт	25.3	573.3	786.5	555.6	-230.9	-29.4
	Экспорт	11.6	163.4	236.4	120.1	-116.3	-49.2
	Импорт	37.5	409.9	550.1	435.5	-114.6	-20.8
	Тэнцэл		-246.5	-313.7	-315.4	-1.7	0.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цаг үеийн онцгой байдлаас шалтгаалж БНХАУ-тай хийх экспортын худалдаа 40.5 хувь буюу 615.7 сая ам.доллараар буурч гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарахад гол нөлөөлөл болсон байна.

ОХУ-тай хийсэн импорт 26.6 сая ам.доллар буюу 7.3 хувиар өсч, БНХАУ-тай хийсэн импортын худалдаа 36.1 сая ам.доллар буюу 9.7 хувиар, бусад орнуудтай хийсэн импортын худалдаа 114.6 сая ам.доллар буюу 20.8 хувиар тус тус буурсан байна. Монгол Улсын гадаад худалдаа нь БНХАУ-тай ашигтай, харин ОХУ-тай алдагдалтай хэвээр байна.

3.2. Экспорт

Экспортын худалдаа 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 735.9 сая ам.доллар буюу 41.5 хувиар буурлаа. Үүнд эрдсийн бүтээгдэхүүний экспорт 592.9 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.7 хувиар буурсан бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувь 0.3 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин тайлант хугацаанд 85.5 хувьд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2.0 пунктээр өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт

Хүснэгт 9.

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл			Өөрчлөлт		Нийт
	/сая ам.доллар/			2020/2019		Экспортод
	2018	2019	2020	сая ам.дол	%	эзлэх %
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	1,252.5	1,478.9	886.0	(592.9)	(40.1)	85.5
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	229.9	292.7	149.8	(142.9)	(48.8)	14.5
Нийт экспорт	1,482.4	1,771.7	1,035.8	(735.9)	(41.5)	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **886.0 сая** ам.долларт хүрч, өмнөх оноос **592.9 сая** ам.доллар буюу **40.1** хувиар буурсан бол, эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **149.8 сая** ам.долларт хүрч, өмнөх оноос **142.9 сая** ам.доллар буюу **48.8** хувиар буурсан байна. Нийт экспортын **85.5** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **14.5** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт

Хүснэгт 10.

№	Төрөл	Хэмжих нэр	2015.03	2016.03	2017.03	2018.03	2019.03	2020.03
1	Зэсийн баяжмал	мян.тн	309.4	412.8	365.8	337.7	361.4	306.6
		сая ам.дол	512.2	481.6	380.2	462.5	503.7	351.2
2	Нүүрс	сая.тн	3.2	3.3	8.1	6.8	7.8	3.1
		сая ам.дол	141.3	99.2	541.3	514.5	641.7	252.4
3	Төмрийн хүдэр	сая.тн	1.0	1.0	1.1	1.4	2.1	2.1
		сая ам.дол	58.2	29.1	70.1	63.9	106.5	141.1
4	Түүхий газрын тос	сая.баррел	1.9	2.2	1.8	1.6	1.6	0.32
		сая ам.дол	91.8	73.2	93.1	101.0	87.8	17.8
5	Алт	тн	2.5	2.9	1.1	2.9	4.7	1.5
		сая ам.дол	98.0	111.3	43.7	124.3	195.9	80.4
6	Цайрын баяжмал	мян.тн	28.2	22.8	27.4	32.9	44.0	36.9
		сая ам.дол	35.0	22.5	40.3	60.2	62.6	48.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Чулуун нүүрс: 252.4 сая ам.долларын 3.1 сая тонн чулуун нүүрс экспортолсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр 389.3 сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд 4.6 сая тонноор тус тус бага байна. 2019 оны мөн үед 1 тонн нүүрсний хилийн дундаж үнэ 83.0 ам.доллар байсан бол энэ онд 80.9 ам.доллар болсон байна. Чулуун нүүрсний 96.3 хувийг БНХАУ руу гаргасан байна.

Зэсийн баяжмал: 306.6 мянган тонн зэсийн баяжмал экспортлосон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 54.8 мянган тонноор бага байна. Өнгөрсөн оны мөн үед зэсийн баяжмалын дундаж үнэ 1,393.9 ам.доллар, экспорт үнийн дүн 503.7 сая ам.доллар байсан бол энэ онд дундаж үнэ 1,145.5 ам.доллар, үнийн дүн 351.2 сая ам.доллар болж буурчээ.

Цайрын баяжмал: Тайлант хугацаанд 36.9 мянган тоннд хүрч 1 тонныг дунджаар 1,309.7 ам.доллараар экспортлосон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ 114.8 ам.доллараар буурсан байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр 48.3 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 14.3 сая ам.доллараар буурчээ.

Жонш: Тайлант хугацаанд 35.3 сая ам.долларын 137.1 мянган тонн жонш экспортлосон нь 2019 оны мөн үеийн гүйцэтгэлээс 26.5 мянган тонноор өссөн ч, үнийн дүнгээр 5.3 сая ам.доллараар буурсан байна. Жоншны экспортын дундаж үнэ 257.2 ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 109.4 ам.доллараар буурсан байна. Жоншийг БНХАУ, ОХУ, БНСУ, Узбекистан руу экспортолсон ба 27.5 хувь ОХУ-д, 71.5 хувь БНХАУ-д тус тус ногдож байна.

3.3 Импорт

2020 оны 03 дугаар сарын гүйцэтгэлээр импортын хэмжээ 1,161.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 124.1 сая ам.доллар буюу 9.7 хувиар буурсан байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт 284.0 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 31.4 сая ам.доллар буюу 10.0 хувиар, эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 877.6 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 92.7 сая ам.доллар буюу 9.6 хувиар тус тус буурсан байна.

Нийт импортын 24.4 хувийг нь эрдсийн бүтээгдэхүүний импорт, 75.6 хувийг нь эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт

Хүснэгт 11.

/сая ам.доллар/

Үзүүлэлт	1 дүгээр улирал				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2017	2018	2019	2020	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	192.0	278.8	315.4	284.0	(31.4)	(10.0)	24.4
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	584.2	851.6	970.3	877.6	(92.7)	(9.6)	75.6
Нийт импорт	776.2	1,130.5	1,285.7	1,161.6	(124.1)	(9.7)	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 63 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 32 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 28 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 1 сая ам.доллараар тус тус буурснаар нийт импорт 124 сая ам.долларын бууралттай гарсан байна.

Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

Хүснэгт 12.

/сая ам.доллар/

Бүтээгдэхүүн	Эхний улирлын гүйцэтгэл						Өөрчлөлт
	2018		2019		2020		
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол 2020/2019
Хэрэглээ	322.0	28%	351.0	27%	320	28%	(32)
- Түргэн эдэлгээтэй	175	15%	170.0	13%	178	15%	(8.0)
- Удаан эдэлгээтэй	147.0	13%	181.0	14%	142	12%	(39)
Хөрөнгө оруулалт	400.0	35%	519.0	40%	456	39%	(63)
- Машин, механик тоног төхөрөөмж, эд анги	256.0	23%	375.0	29%	318	27%	(57)
- Барилгын материал	93.0	8%	104.0	8%	97	8%	(7)
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	51.0	5%	40.1	3%	41.1	3%	(0)
Аж үйлдвэрлэлийн орц	176.0	16%	147.0	11%	146	13%	(1)
- Цахилгаан эрчим хүч	36.0	3%	37.0	3%	38	3%	1
Нефтийн бүтээгдэхүүн	231.0	20%	267.0	21%	239	21%	(28)
- Дизель	134.0	12%	163.0	13%	125	11%	(38)
- АИ-92, 95	55.0	5%	69.0	5%	63	5%	(6)
- А80 ба бусад	42.0	4%	35.0	3%	50	4%	15.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Импортын бүтээгдэхүүний бууралтад хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 63.0 сая ам.долларын бууралт голлон нөлөөлжээ. Импортын 10 нэгж хувийн бууралтыг ерөнхий ангилалаар авч үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 5 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 2 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 2 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оноос 32.0 сая ам.доллараар буурахад авто машин, түүний сэлбэг хэрэгсэл 40 сая ам.доллараар буурсан нь нөлөөлөв.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 63 сая ам.доллараар буурахад машин механик, тоног төхөөрөмж, эд ангийн 37 сая ам.доллар, суудлаас бусад тээврийн хэрэгсэл эд ангийн 19 сая ам.долларын бууралтууд гол нөлөө үзүүлжээ.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оны мөн үеэс 28 сая ам.доллараар буурсан байна. Үүнд дизель түлшний импорт 38 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

ДӨРӨВ. МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 20,451.8 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 752.2 тэрбум төгрөг буюу 3.8 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 952.7 тэрбум төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн нь нөлөөлжээ. Валютын хадгаламж 789.4 тэрбум төгрөг буюу 27.3 хувь, валютын харилцах 590.6 тэрбум төгрөг буюу 29.7 хувиар тус тус өссөн байна.

Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

Хүснэгт 13.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-) 2020.03/2019.03	
	2017	2018	2019	2020	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	12,259.3	16,073.9	19,699.6	20,451.8	752.2	3.8%
Бараг мөнгө	10,134.5	13,297.2	16,032.9	16,985.6	952.7	5.9%
- Төгрөгийн хадгаламж	6,464.3	8,859.4	11,147.8	10,720.5	-427.3	-3.8%
- Валютын хадгаламж	2,347.4	2,513.2	2,896.8	3,686.2	789.4	27.3%
- Валютын харилцах	1,322.8	1,924.6	1,988.3	2,578.9	590.6	29.7%
M1 мөнгө	2,124.9	2,776.7	3,666.6	3,466.2	-200.4	-5.5%
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	788.3	840.4	897.8	847.8	-50.0	-5.6%

Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 17.1 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 0.3 их наяд төгрөг буюу 1.8 хувиар буурсан байна.

Зээлийн өрийн үлдэгдэл

Хүснэгт 14.

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	1 дүгээр улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-) 2020.03/2019.03	
	2017	2018	2019	2020	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	12,678.5	14,139.5	17,461.9	17,146.5	-315.4	-1.8%
- Хэвийн зээл	10,647.9	11,971.8	14,683.0	14,163.3	-519.7	-3.5%
- Хугацаа хэтэрсэн зээл	995.1	935.9	913.7	1,150.3	236.6	25.9%
- Чанаргүй зээл	1,035.5	1,231.8	1,865.2	1,832.9	-32.3	-1.7%
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	8.2	8.7	10.7	10.7	0.0	0.1%
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	7.8	6.6	5.2	6.7	1.5	28.2%

Эх сурвалж: Монголбанк


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 1 дүгээр улирлын эцэст 1,150.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 236.6 тэрбум төгрөг буюу 25.9 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.7 хувь, хэвийн зээлийн 8.1 хувийг тус тус эзэлжээ. Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 80.3 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн зээл, 19.1 хувийг иргэдийн зээл тус тус эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 1 дүгээр улирлын эцэст 1,832.9 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 32.3 тэрбум төгрөг буюу 1.7 хувиар буурсан байна. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.7 хувь, хэвийн зээлийн

12.9 хувийг эзэлсэн байна. Өнгөрсөн оны мөн үеэс чанаргүй зээл буурахад хувийн хэвшлийн зээл 8.9 хувь буюу 140.7 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.


Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2020 оны 1 дүгээр улирлын эцэст нийт **10.4** сая ширхэг үнэт цаас арилжаалагдаж, **9.6** тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээ 5.2 дахин буурсан байна. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар гүйлгээ хийгдээгүй бол хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2020 оны 3 дугаар сард дунджаар **18,208.2** болж, өмнөх оны мөн үеэс 2,691.5 нэгж буюу 12.9 хувиар буурчээ.

Валютын ханш: 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,769.03 төгрөгт хүрч, өмнөх сараас 0.5 хувиар, оны эхнээс 0.9 хувиар суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 391.62 төгрөг болж өмнөх сараас 0.8 хувиар, оны эхнээс 1.3 хувиар чангарсан байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний үнийн улсын индекс 2020 оны 1 дүгээр улирлын эцэст 6.4 хувь болж өмнөх сараас өөрчлөлтгүй, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр буурсан байна.



Эх сурвалж: Монголбанк

4.2. Гадаад валютын албан нөөц

Нийт албан нөөцийн хэмжээ 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 4,094.2 сая ам.долларт хүрээд байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 433.8 сая ам.доллар буюу 11.9 хувиар нэмэгдсэн байна



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 4,094.2 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 11.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын хэмжээ 9.7 хувиар буурсан ч, гадаад валютын албан нөөц 11.9 хувиар өссөн нь импортын сарын хэрэгцээг хангах түвшинг нэмэгдүүлжээ.

Гадаад валютын албан нөөц ба импорт

Хүснэгт 15.

/сая ам.доллар/

№	Үзүүлэлт	2015.03	2016.03	2017.03	2018.03	2019.03	2020.03
1	Нийт импорт	701.7	599.1	776.2	1,130.5	1,285.7	1,161.6
2	Гадаад валютын нийт нөөц	1,323.9	1,265.3	1,109.2	2,983.1	3,660.4	4,094.2
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	6.6	7.9	3.3	8.4	8.9	11.6

Эх сурвалж: Монголбанк, Үндсэний статистикийн хороо

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2020 оны жилийн 1 дүгээр улирлын эцэст 5.3 тонн болж, өмнөх оны мөн үеэс 4.6 тонноор өссөн байна. Монголбанк 2020 оны 03 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр нийт 5.3 тн үнэт металл худалдан авсан ба үүнээс 3.6 тн алт, 1.7 тн цагаан мөнгө байна.

2020 оны 03 дугаар сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 31 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 36 кг үнэт металл тус тус худалдан авсан байна. Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 03 дугаар сард 141,512.11 төгрөг байсан байна.



Эх сурвалж: Монголбанк

4.3. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар урсгал тэнцэл 669.1 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 337.9 сая ам.долларын илүүдэлтэй, төлбөрийн тэнцэл 350.2 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 569.8 сая ам.доллараар буурсан байна.

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар урсгал тэнцлийн алдагдал 669.1 сая ам.доллар, үүний дотор цэвэр урсгал шилжүүлэг 78.6 сая ам.доллар гарсан бол бараа ба үйлчилгээ 584.3 сая ам.доллар, цэвэр орлого 163.3 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал тэнцлийн алдагдал 271.0 сая ам.доллараар өссөн байна. Урсгал тэнцлийн алдагдал өсөхөд бараа ба үйлчилгээний алдагдал 401.7 сая ам.доллараар өссөн нь нөлөөлжээ.

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 337.9 сая ам.долларын илүүдэлтэй гарсан нь өмнөх оны мөн үеэс 244.3 сая ам.доллараар буурсан байна. Төлбөрийн тэнцэл 350.2 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 569.8 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм.

Төлбөрийн тэнцэл, 2018.03 - 2020.03

Хүснэгт 16.

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Гүйцэтгэл			1 дүгээр улирлын өөрчлөлт (+/-)	
	2018.03	2019.03	2020.03	2019/2018	2020/2019
I. Урсгал Тэнцэл	-440.9	-398.1	-669.1	42.8	-271.0
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-308.0	-182.7	-584.3	125.3	-401.7
В. Орлого	-212.9	-288.6	-163.3	-75.7	125.3
С. Урсгал шилжүүлэг (цэвэр)	80.0	73.2	78.6	-6.7	5.3
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл	312.6	582.2	337.9	269.7	-244.3

А. Хөрөнгийн данс	15.0	24.7	17.7	9.6	-7.0
В. Санхүүгийн данс	297.5	557.6	320.2	260.0	-237.3
III. Алдаа болон орхигдуулга	86.2	35.4	-19.0	-50.8	-54.4
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-42.2	219.6	-350.2	261.8	-569.8

Эх сурвалж: Монголбанк

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Хүн ам, ажил эрхлэлт

2020 оны хүн амын улсын ээлжит тооллогын дүнд Монгол Улсын хүн ам 3 296 866, өрхийн тоо 897 427 болсон байна. Хүн амын тоо 2010-2020 оны хооронд жилд дунджаар 2.2 хувиар өсчээ. Жилийн дундаж өсөлт өмнөх тооллогоос 0.7 пунктээр нэмэгдсэн нь хүн амын цэвэр өсөлт сүүлчийн арван жилд их байсантай холбоотой байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн 31.8 мянган хүнээс 19.4 мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 12.4 мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Өмнөх онтой харьцуулахад бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 17.5 хувь буюу 937-р буурсан байна.

Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн 58.7 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн/халадсан, 22.7 хувь нь сургууль төгсөөд ажилгүй байгаа, 14.0 хувь нь шилжин суурьшсан шалтгаанаар ажилгүй иргэд эзэлж байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 55.4 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна.

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1,253.1 мянга болж, өмнөх оноос 43.6 мянган хүнээр буурсан байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 59.0 хувь болж өнгөрсөн оноос 1.7 пунктээр буурсан байна. Харин 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 872.0 мянга болж, өмнөх оноос 32.9 мянган иргэдээр өссөн байна. Тэдгээрийн 82.3 (9.4%) мянга нь цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүчинд багтаж байна.

5.2. Ажилгүйдэл

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 6.6 хувьтай болж, өнгөрсөн оны мөн үеэс 5.2 пунктээр, өмнөх улирлаас 1.5 пунктээр тус тус буурсан байна. Түүнчлэн 2016 оны мөн үетэй харьцуулахад ажилгүйдлийн түвшин 5.0 пунктээр буурчээ. Ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурч, хөдөлмөр эрхлэлтийн түвшин өсч байгаа нь ажиглагдаж байна.


ДҮГНЭЛТ**1. Эдийн засагт гарч буй нааштай өөрчлөлтүүд**

- **Төсвийн зарлагын хэмнэлтийн нөлөөллөөр нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал буурлаа.** 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр төсвийн тэнцлийн ДНБ-нд эзлэх хувь -0.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр буурсан ч 2020 оны 1 дүгээр улирлын -3.0 хувийн алдагдалтай төлөвлөсөн дүнгээс 2.3 пунктээр нэмэгдэж, төсвийн алдагдлын хэмжээ буурсан байна.
- **Мөнгөний нийлүүлэлт өслөө.** Мөнгөний нийлүүлэлт 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 20,451.8 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 752.2 тэрбум төгрөг буюу 3.8 хувиар өссөн байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 83.1 хувийг төгрөгийн хадгаламж, валютын хадгаламж, валютын харилцах, үлдэх 16.9 хувийг банкны харилцах, гүйлгээнд гарсан бэлэн мөнгөний өсөлт нөлөөлжээ.
- **Инфляци буурсан байна.** 2020 оны 1 дүгээр улирлын эцэст инфляцийн түвшин 6.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.3 пункт, 2018 оны 1 дүгээр улирлаас 0.2 пунктээр тус тус буурсан байна. Энэ нь Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл болон Монгол Улсын 2020 оны төсвийн төсөлд тусгасан инфляцийг 8.0 хувьд барих бодлогоос даруй 1.6 пунктээр буурсан үзүүлэлт юм.
- **Гадаад валютын албан нөөц тогтвортой өсч, импортын хэрэгцээг хангах түвшин нэмэгдэж байна.** Гадаад валютын албан нөөц өмнөх жилүүдэд тасралтгүй буурч 2016 оны 9 сард 1,092.4 сая ам.долларт хүрсэн хэдий ч 2017 оны эхнээс эргэн өсч 2020 оны 03 сард 4,094.2 сая ам.доллар болсон байна. Энэ нь сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 11.6 сарын хэрэгцээг хангах түвшинд болж өмнөх оны мөн үеэс 2.7 пунктээр өссөн үзүүлэлт юм.
- **Ажилгүйдлийн түвшин буурч байна.** 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 6.6 хувьтай болж, өмнөх оны мөн үеэс 5.2 пунктээр, өмнөх улирлаас 1.5 пунктээр тус тус буурсан байна. Түүнчлэн 2016 оны мөн үетэй харьцуулахад ажилгүйдлийн түвшин 5.0 пунктээр буурчээ. Ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурч, хөдөлмөр эрхлэлтийн түвшин өсч байгаа нь ажиглагдаж байна.

2. Нийгэм, эдийн засагт тулгамдаж буй зарим асуудал

- **Эдийн засгийн өсөлт буурлаа.** 2011 онд 17.5 хувь байсан эдийн засгийн өсөлт тасралтгүй буурч 2016 оны эхний 3 дугаар улиралд -1.4 хувьд хүртэл унасан. Харин 2016 оны 3 дугаар улирлаас хойш аажмаар өссөөр 2019 оны жилийн эцсийн байдлаар 5.1 хувьтай боллоо. Коронавирусын тархалттай холбоотойгоор 2020 оны эхний улиралд ДНБ 10.7 хувиар буурсан ба үүний -7.6 пункт нь уул уурхай, олборлолтын салбарт ногдож байгаа нь гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон экспорт өмнөх оны мөн үеэс буурсантай холбоотой байна.
- **Төсвийн орлого буурсан байна.** Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 2,073.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 89.6 тэрбум, төлөвлөгөөнөөс 111.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна. Тайлант хугацаанд орлогын албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас бусад татварын орлогууд дутуу биелжээ.
- **Гадаад худалдааны тэнцэл алдагдалтай гарч, экспорт болон импортын худалдаа буурлаа.** Экспорт 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 1,035.8 сая ам.доллар болж 735.9 сая ам.доллар буюу -1.5 хувь, мөн импорт 1,161.6 сая ам.долларт хүрч 124.1 сая ам.доллар буюу 9.7 хувиар тус тус буурчээ. Гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн

- үеэс 611.7 сая ам.доллар буюу 125.9 хувиар буурч 125.8 сая ам.долларын алдагдалтай боллоо.
- **Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа.** Төлбөрийн тэнцэл 2020 оны 03 сард 350.2 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Үүнд бараа ба үйлчилгээ 584.3 сая ам.доллар, цэвэр орлого 163.3 сая ам.долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлжээ.
 - **Чанаргүй зээл буурсан ч хугацаа хэтэрсэн зээл өссөн байна.** 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар хугацаа хэтэрсэн зээл 236.6 тэрбум төгрөгөөр буюу 25.9 хувиар өсч 1,150.3 тэрбум төгрөгт хүрлээ. Хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.7 хувийг эзэллээ.
 - **Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааны идэвх багассан.** Үнэт цаасны арилжаа хумигдаж, гүйлгээ 9.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 5.2 дахин буурчээ.
 - **Зээлийн үйлчилгээний төлбөр буурсан байна.** Нэгдсэн төсвийн зээлийн үйлчилгээний төлбөр 2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 185.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 8.9 хувь, нийт зарлагын 7.9 хувийг эзэлж байна. 2015 оны мөн үетэй харьцуулахад зээлийн үйлчилгээний төлбөр 2020 оны 1 дүгээр улиралд 2.9 дахин өссөн байна. Харин 2018 оны мөн үетэй харьцуулахад зээлийн үйлчилгээний төлбөр 44.8 тэрбум төгрөгөөр буюу 19.5 хувиар буурсан байна. Цаашид зээлийн үйлчилгээний төлбөрийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Түүнчлэн зээлийн үйлчилгээний төлбөр тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 7.6 тэрбум төгрөгөөр бага байгаа нь улсын төсөвт нөлөөлөх хүүгийн зардал буурах төлөвийг харуулж байна.



- **Хөрш орны эдийн засгаас хамааралтай, түүхий эдэд суурилсан экспортын бүтэцтэй хэвээр байна.** Нийт экспортын 90 гаруй хувийг баяжмал, хүдэр, түүхий эд зонхилж байна. Нийт гадаад худалдааны эргэлтэд хөрш орнууд дийлэнх хувийг эзэлж байна. Нэмүү өртөг шингэсэн томоохон үйлдвэрүүдийг шинээр барих, мега төсөл, хөтөлбөрүүдийг эдийн засгийн эргэлтэд шуурхай, хугацаа алдалгүй оруулах, ЖДҮ эрхлэгчдийг төсөв, санхүүгийн бодлогоор дэмжих замаар шинээр ажлын байр нэмэгдүүлэх, импортыг орлуулах, экспортыг дэмжсэн үйлдвэрлэлийг өсгөх, экспортын бүтцэд өөрчлөлт гаргах нь зүйтэй байна.

---oOo---

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА